

Хувилбар №	2.2	Батлагдсан огноо	2023-06-28
------------	-----	------------------	------------



ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Домэйн:	Хууль, хянан нийцүүлэлтийн алба
Эзэмшигч:	Хууль, хянан нийцүүлэлтийн алба
Баримт баталсан:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хувилбар #:	1.0
Шийдвэр # (хэрэв байгаа бол)	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 сарын 28-ны өдрийн BR 23/024 дугаар тогтоол

Хувилбар №	2.2	Батлагдсан огноо	2023-06-28
------------	-----	------------------	------------

"Төнгэр Даатгал" ХХК-ийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 06
дугаар сарын 28-ний өдрийн BR 23/024 тоот тогтоолын
Хавсралт №1



АГУУЛГА

НЭГ. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР.....	4
ХОЁР. ЕРӨНХИЙ УДИРДАМЖ	4
ГУРАВ. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХУВЬД ӨГӨХ АМЛАЛТ	4
ДӨРӨВ. ЗАХ ЗЭЭЛ буюу ДААТГУУЛАГЧИДДАА ӨГӨХ АМЛАЛТ.....	6
ТАВ. АЖИЛТНУУДДАА ӨГӨХ АМЛАЛТ	9
ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДДЭЭ ӨГӨХ АМЛАЛТ	10
ДОЛОО. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА.....	11

3.1 Тогтвортой байдал

Тогтвортой байдлыг хангаж ажилласнаар нийгэм, байгаль орчиндоо эерэг, зөв зүйтэй өөрчлөлтийг бий болгох, асуудлыг дэвшүүлэхэд өөрсдийн зүгээс тусалж чадна.

Даатгалын үйлчилгээ нь даатгуулагчдыг аливаа эрсдэл үүссэний дараа санхүүгийн хүндрэлээс аврах, хэвийн амьдралын хэв маягийг үргэлжүүлэх, бизнесийн үйл ажиллагаагаа дахин сэргээхэд нь тусалдагаараа онцлог олон жилийн түүхтэй санхүүгийн үйлчилгээ юм.

3.2 Улс төрийн үйл ажиллагаа

Хувь хүний улс төрийн үйлдэл, ашиг сонирхол нь түүний компанид хийж байгаа ажил үүрэгтэй зөрчилдөхгүй, Компанийн нөлөөтэй мэт харагдахгүй байх нь чухал юм. Ялангуяа дараах асуудлуудыг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Сонгуульд өрсөлдөж байгаа Компанийн ажилтан тус компанид ажилладаг гэхээс өөрөөр хэзээ ч Компанийн нэрийг ашиглаж болохгүй.
- Ажилтан сонгуульд өрсөлдөж, улс төрийн намд харьяалагдах нь түүний Компанид хийж байгаа ажилтай ашиг сонирхлын зөрчил үүсгэхээр эсвэл үүсгэсэн мэт харагдах ёсгүй.
- Компанийн өмч хөрөнгийг улс төрийн лобби хийх, улс төрийн зорилгоор ашиглах ёсгүй.

3.3 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх

Компани болон түүний ажилтнууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс зайлсхийж, “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, Санхүүгийн зохицуулах хорооны “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”, “Комплаенсын гарын авлага”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллана. Дээрх хариуцлага нь ерөнхийдөө харилцагчаа тодорхойлох, харилцагчийн үйлдлийг хянах, сэжиг бүхий эсхүл харилцагчийн сэжигтэй гүйлгээг хууль, дүрмийн дагуу мэдүүлэх үйл ажиллагаа юм.

3.4 Олон нийттэй харилцах

Зөвхөн зөвшөөрөгдсөн ажилтан Компанийн нэрийн өмнөөс ярилцлага өгөх эрхтэй бөгөөд тэдний өгч буй мэдээлэл бүрэн гүйцэд, шударга, үнэн зөв, цаг үедээ тохирсон, ойлгомжтой байх ёстой.

3.5 Авлига, хээл хахуулийн эсрэг

Компани нь бусдын бизнесийн үйл ажиллагааны шийдвэрт зүй бусаар нөлөөлөх ёсгүй. Компанийн ажилтан, төлөөлөгч, бие даасан гэрээт компани бизнесийн ашиг хонжоо, бизнесийн үйл ажиллагаанд ашигтай байдал авчрахын тулд бусдад хахууль өгөх, өндөр үнийн дүн бүхий ёс зүйгүй бэлэг сэлт өгөхийг хориглоно.

- Аливаа хандив, тусламж нь бизнесийн үйл ажиллагаанд эерэг үр дүн авчрахаар бол энэ нь Авлигын эсрэг хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд заавал бичгээр дүгнэлт гаргах хэрэгтэй.

Хувилбар №

2.2

Батлагдсан огноо

2023-06-28

- Өрсөлдөгчдийн нууц мэдээллийг зөвхөн хууль ёсны, зүй зохистой эх сурвалжаас авах.
- Өрсөлдөгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар зөвхөн бодит мэдээлэл дээр тулгуурлан дүгнэлт хийх.

Болохгүй:

- Албан, албан бусаар өрсөлдөгчидтэй үнийг тогтворжуулах, худалдааны бусад нөхцөлийг тохирох, тендерийг луйвардаж авах, даатгуулагч эсхүл, зах зээл болон газар нутгийг хуваарилах.
- Даатгалын үндсэн зарчим, хууль дүрмийг зөрчсөн аливаа шийдэл, үйлдлийг тохирох, санал болгох.
- Өрсөлдөгч эсхүл тэдний бүтээгдэхүүн, үйлчилгээнд бодит бус, худал харьцуулалт хийх.
- Өрсөлдөгч эсхүл тэдгээр өрсөлдөгчдийн нууцыг хадгалах үүрэгтэй этгээдээс нууц мэдээлэл олж авах.

4.2.3 Өрсөлдөөний мэдээлэл

Өрсөлдөгч, тэдний даатгуулагчийн хувийн мэдээлэл зэрэг бүх нууц мэдээллийг хууль бусаар, ёс бусаар ашиглахыг хориглоно. Өрсөлдөгчийн мэдээллийг зөвхөн хууль ёсны, зохих ёсны эх сурвалжаас авах ёстой.

4.3 Ашиг сонирхлын зөрчил

Гишүүдийн эрх бүхий ажилтан нь тухайн албан тушаалыг өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хувийн ашиг хонжоо олох, эсхүл давуу тал болгож буруугаар ашиглах ёсгүй. Хувийн ашиг сонирхол болон гишүүн байгууллагын ашиг сонирхлын хооронд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсхүл үүсэх магадлалтай бүх тохиолдлоос зайлсхийх ёстой.

4.3.1 Ашиг Сонирхлын Зөрчил

- Ажилтан нь үргэлж байгууллага болон даатгуулагчдын ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэр гаргана – хувийн ашиг сонирхлоо дагахгүй.
- Даатгуулагч, төлөөлөгч эсхүл өрсөлдөгчдөд хөрөнгө оруулалт хийх, эсхүл эдгээрт давхар ажил хийх гэх мэтчилэн хувь хүний үйлдэл хэрхэн ашиг сонирхлын зөрчилд хүргэж болзошгүй вэ гэдгийг байнга санаж ажиллана.
- Ажилтан нь удирдах албан тушаалтантайгаа ашиг сонирхлын зөрчил гэж үзэж болох нөхцөл байдлын талаар ярилцах хэрэгтэй.
- Ажилтан өөрөө болон гэр бүлийн гишүүн, эсхүл танил, найз нөхдийн ашиг сонирхол гишүүн байгууллагын ашиг сонирхлын зөрчилд орж болзошгүй нөхцөл байдлыг өөрийн санаачилгаар мэдэгдэх үүрэгтэй.

4.3.2 Компанийн боломжууд

Компанийн ажилтан нь компанийн өмч, албан мэдээлэл, өөрийн албан тушаалыг ашиглан олж авсан бизнесийн боломжийг өөрсдөдөө ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд шилжүүлэхийг бусад байгууллагад санал болгож бусад байгууллага татгалзснаас бусад тохиолдолд хориглоно. Ажилтан нь компанийн өмч, мэдээлэл эсвэл албан тушаалыг хувийн ашиг тусын тулд бусад байгууллагыг гадуурхах, бусад байгууллагатай өрсөлдөх байдлаар ашиглахыг хориглоно.

4.3.3 Ажлаас гадуурх үйлдлүүд

Хувилбар №

2.2

Батлагдсан огноо

2023-06-28

Бизнесийн түншүүдтэйгээ баримталдаг харилцаа нь дараах зарчимтай байвал зохино.
Үүнд:

- Үйлчилгээг хэрхэн зөв зохистой аргаар үзүүлж байгааг баталгаажуулахын тулд гишүүн байгууллагууд хамтран ажиллахаар бэлтгэж буй болон ажиллаж буй бизнесийн түншүүдийн үйл ажиллагааг анхааралтай ажигла.
- Аливаа төлөөлөгч, зөвлөх, бие даасан гүйцэтгэгчээс үйлчилгээ авахын өмнө урьдчилсан мониторинг хийх.
- Бизнесийн түнш, хамтран ажиллагчийг эсхүл төлөөлөгчийг зүй бус үйлдэлд хамтрахыг тэвчих.
- Бизнесийн түнш, төлөөлөгчдийг хүндэтгэж, ойлгож харьцах. Хамтран ажиллахдаа “харилцан ойлголцох, харилцан хүндэтгэх, харилцан үр ашигтай байх” гэсэн 3 зарчмыг анхаарч ажиллах.

ТАВ. АЖИЛТНУУДДАА ӨГӨХ АМЛАЛТ

5.1. Бусдыг хүндэтгэх

Бусдыг хүндэтгэх гэдэг нь бие биенийхээ ялгаатай, өөр байдлыг ойлгож, үнэлж, хүндэтгэх явдал юм.

Ажилтнууд бусдын үзэл бодлыг хүндэтгэж, бусдыг дарамтлах, заналхийлэх байдлаар хандах ёсгүй.

5.2 Дарангуйлалгүй ажлын орчныг бүрдүүлэх:

- Үл таалсан байдлаар дохих, бусдын биед хүрэхгүй байх.
- Бэлгийн эрээ цээргүй, доромжилсон зураг, бусад материалыг ил байлгахгүй байх.
- Бэлгийн эсхүл доромжилсон аястай тоглоом хийх, үг яриа хэрэглэхгүй байх. (доромжлох эсвэл далд санаагаар илэрхийлэх)

5.3 Ажилтны өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх

- Ажилтнуудыг тэдний ажлын гүйцэтгэл болон ажлын гүйцэтгэлтэй хамааралтай онцлог шинж чанаруудад нь тулгуурлан урамшуулах, боломж олгох.
- Ялгаварлан гадуурхах, дарамт болон шахалтыг тусгасан холбогдох хөдөлмөрийн хуулийг чандлан сахих.
- Зохисгүй дарамт шахалтаас ангид ажлын орчноор хангах.
- Ажлын байрны орчин нөхцөлтэй холбоотой эрх зөрчигдөж буй аливаа асуудлыг хүний нөөцийн менежертээ мэдэгдэх.

5.4. Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн шаардлага хангасан ажлын байраар хангах

Компани нь ажилтнууд болон даатгуулагчдынхаа аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан барилга байшинд үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэнэ.

Ажилтнууд ажлын байран дээрээ гүйцэтгэж буй ажилдаа нарийн няхуур, сонор сэрэмжтэй хандаж, гарч болзошгүй зөрчил, аюул осол, гарз хохирол, хулгай дээрэм зэргээс урьдчилан сэргийлнэ.

5.5 Архи, согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэх

- Оюуны өмчийг хамгаалахын тулд патент, худалдааны тэмдэг, зохиогчийн эрхийг зүй ёсоор авч эсвэл бусдад авахад нь туслана.
- Өмнөх ажил олгогчийнхоо оюуны өмчийг зөвшөөрөлгүйгээр ашиглахгүй.
- Лицензийн гэрээнд зааснаас бусад үед хэзээ ч битгий хуулбар программ хангамж, бичиг баримт ашиглаарай. Компани нь программ хангамж хөгжүүлэгч, борлуулагчаас программ хангамжид тавьж буй хязгаарлалтыг хүндэлдэг.

6.4.3 Мэдээлэл технологийн систем

Байгууллагын мэдээлэл технологийн системд компьютер, сүлжээний төхөөрөмжүүд, и-мэйлийн систем, утсан харилцаа холбоо, дуут харилцаа холбоо, бусад компьютероос гарч буй мэдээлэл зэрэг багтана. Эдгээр систем, эдгээр системд байрлаж буй мэдээллийн санд зүй бусаар хандах, түүнийг гэмтээх, хулгайлахаас хамгаалах үүрэгтэй.

Бизнесийн дотоод журам, мэдээллийн сангийн журам, “Нууцын тухай хууль”-д нийцүүлэн мэдээлэл даатгуулагчийн болон компанийн мэдээлэл алдагдаж буй эсэхэд хяналт тавих, компанийн хэмжээнд ашиглагдаж буй цахим мэдээллийг боловсруулах, хадгалах төхөөрөмж, цахим и-мэйл болон бусад цахим мэдээллийг хянаж шүүх хэрэгтэй.

6.4.4 Нууц мэдээллээ хадгалах

- Бусдын мэдээлэлд зөвшөөрөлгүйгээр нэвтрэхгүй байх.
- Мэдээллийг бусдад санамсаргүй болон санаатай байдлаар шилжүүлэхгүй байх.
- Олон нийтийн дунд хүмүүс сонсож болзошгүй байхад нууц мэдээллийг чангаар, нээлттэй ярихаас зайлсхийх хэрэгтэй.
- Хөрөнгө эзэмшлийн талаар гуравдагч этгээдтэй зөвшөөрөлгүйгээр, нууц хадгалах гэрээ байгуулаагүйгээр ярихаас зайлсхийх хэрэгтэй.
- Хөрөнгө эзэмшлийн талаар даатгуулагч, бизнесийн түнштэй зохих ёсны зөвшөөрөл авалгүйгээр, нууц эсвэл нууц биш гэсэн харилцаатай эсэх талаар мэдэхгүйгээр ярихаас зайлсхийх хэрэгтэй.
- Нууц баримт бичгийг зүй бусаар хаях, үрэгдүүлэхээс зайлсхийх хэрэгтэй.

ДОЛОО. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

Компанийн ажилчид болон эрх бүхий албан тушаалтнууд ёсзүйн хэм хэмжээг дагаж мөрдөх үүрэгтэй ба хэрэв ёсзүйн хэм хэмжээг ноцтойгоор зөрчсөн, тус үр дүн нь компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц хэмжээний хохирол учирсан тохиолдолд хариуцлага хүлээнэ.

7.1. Комплайнсын мэргэжилтэн томилох.

ТУЗ-өөс комплайнсын мэргэжилтэнг томилж, шууд харьцана. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь комплайнсын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдэд шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг үзүүлж, бие даасан хараат бус байдлыг хангана.

7.2. Хяналт хэрэгжүүлэх.